

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
МОНГОЛ ХЭЛ СОЁЛЫН СУРГУУЛЬ
ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БИЧИГ

Том. XXXI (328)

2010

254-264

**ОРЧИН ҮЕИЙН ЯРУУ НАЙРГИЙН ТУУРВИЛ ЗҮЙД
БЭЛГЭДЛИЙГ АШИГЛАСАН ТУРШЛАГА**

Р.Бигэрмаа¹

Түлхүүр үг: Монголын орчин үеийн уран зохиол, бэлгэдэл зүй, яруу найраг, уламжлал шинэчлэл, өнгө, дүрс, тооны бэлгэдэл, зан заншил, гэр

Төв Азийн нүүдэлчин Монголчуудын оюуны соёлын нэгэн чухал дурсгал болох утга зохиол нь мянгаад жилийн туршид өөрийн түүхэн өв, баялаг уламжлал, туршлага дээр тулгуурлан хөгжсөөр ирсэн билээ.

Аливаа улс үндэстний утга зохиолын хөгжил нь тэр улсынхаа нийгэм, соёлын хөгжил дэвшилтэй салшгүй холбоотой байдаг бөгөөд Монголын шинэ үеийн яруу найраг цаг үеэ шуурхай тусгадаг зүй тогтлын дагуу, өмнөх үеийн дэвшилт өв уламжлал, дэлхийн улс орнуудын сонгодог жишээн дээр суурilan нийгмийн хөгжилтэй зэрэгцэн, уламжлал болж хөгжин дэвшиж ирсэн билээ.

Монгол бичгийн уран зохиолын хөгжлийн түүхэнд уламжлал болсон ардын аман зохиолд бэлгэдэл зүйг эртнээс нааш хэрэглэж ирсэн арвин уламжлалтай юм. Монгол ардын аман зохиол бэлгэ дэмбэрлийн үгс, ерөл, магтаал, оньсого, зүйр цэцэн үг зэрэгт бэлгэдлийг ихэд хэрэглэдэг байжээ. Энэ нь ард түмний амьдралын өвөрмөц онцлог, хэв маяг, зан заншилаас шалтгаалан, тэдний урлаг уран зохиолд тусгалаа олж, ямар нэгэн зүйлийг сайн, муу хоёр хэлбэрээр бэлгэддэг байсан байна.

Аливаа зүйл нь хий хоосноос бий болохгүй, өмнөх үеийн уламжлал дээр тулгуурлан, шинэчлэгдэж өөрчлөгдөж ирдэг зүй тогтлын дагуу орчин үеийн уран зохиол, тэр тусмаа яруу найргийн төрөлд ч бэлгэдэл зүйн бүтвэрүүд тодорхой хэмжээгээр тусгагдаж, өвөрмөц өөрийн гэсэн шинэ агуулга, шинж төлвийг бий болгож иржээ.

Иймд XX зууны яруу найргийн хөгжилд өөрийн гэсэн зохих хувь нэмрээ оруулж, шинэчлэл хийсэн хэмээн үздэг Д.Нацагдорж, Б.Явуухулан, Б.Лхагвасүрэн нарын уран бүтээлд бэлгэдэл зүйн тусгал хэр байгаа тухай өчүүхэн судалгааг хийлээ.

Монголын орчин үеийн уран зохиолыг үндэслэгч Д.Нацагдоржийн уран бүтээлд ардын аман зохиолын нөлөө их байснаас бэлгэдэл зүйн бүтвэрүүд түүний уран бүтээлд тусгалаа олж, шинэ хэлбэршлийг олж байжээ. Энэ талаар олон эрдэмтэд тодорхой хэмжээний судалгаа хийсэн боловч цаашид илүү их судлах шаардлагатай юм. Тухайлбал: Профессор Д.Галбаатар “Октябрь” шүлэг, “Хуучин хүү”, “Цагаан сар ба хар нуулимс” болон түүний уран бүтээл дэх бэлгэдэл зүйн хэв шинжүүдийн тухай, эрдэмтэн Р. Нарантуяа, Ч.Жачин, Зөвлөлтийн эрдэмтэн К.Н.Яцковская нар сонирхолтой дүгнэлтүүдийг хийсэн билээ.

¹ МУИС-ийн Монгол хэл, соёлын сургууль.

Д.Нацагдоржийн яруу найргийг ажиглан үзвэл, түүний шүлгүүдэд монголчуудын бэлгэдэлт сэтгэлгээний бүтвэр махбод элбэг тохиолддог. Тухайлбал: “Од” шүлгийг авч үзье. Монголчууд эрт дээр үэс Эх дэлхий, эцэг тэнгэр хэмээн хүндлэн биширч тэнгэр огторгуйдаа залбиран мөргөж, хувь заяагаа даатгасаар иржээ. Түүний уран бүтээлд ч энэхүү тэнгэрийн эрхест хандсан “Нар aa”, “Cap aa”, “Од” зэрэг шүлгүүд байдаг. Одон гараг гэдэг бол энэхүү эцэг тэнгэрийн нэгэн бүтэц бүрэлдэхүүн. Ялангуяа монголчууд “Долоон бурхан од”-ыг хүндлэн дээдэлж, өөрийн хүслийг шивнэн, бүтэхийг бэлгэдэж, сүү өргөдөг заншилтай. Энэхүү бэлгэдлийг тэрээр уг шүлэгтээ тусган харуулж, ирээдүйд хүн төрөлхтөн сансарт нисэхийг өвөрмөц байдлаар бэлгэдэн өгүүлсэн аж.

Одон чиний тэндээс энэхүү дэлхий ямар өнгөтэй үзэгднэм

Орчлонт ертөнц хэмээгчийг чи мэднэ үү, үгүй юу?

Янаглал амраглалын дал аль зэрэг хурц буй?

Ягунда (юунд) манай ертөнцөд захияа үл илгээмүй чи

Нөгөө талаар, ирээдүйд хүний төрөлхтний эрдэм боловсрол-оюун ухаан, шинжлэх ухаан техник улам хөгжиж, энэхүү орчлон ертөнцөөс хальж, сансар огторгуй, одон гарагийг судлах цаг ирнэ хэмээн, үүнийгээ “эрдэмт марс од oo” хэмээн тэрхүү одыг эрдэм, оюун ухааны бэлгэдэл болгон өгүүлсэн нь биеллээ олсоор байна. Энэ нь:

Эрдэмт марс од oo ! Чи нэгд нэгээр харж байна.

Энэхүү дэлхийн түмэн байдлыг юу гэж сонирхено чи

“Огторгуйн оргилын олон эрдэмтэн чамайг хэдийнээс сонирхов

Урьдаар нийгэм журмыг байгуулж, дараагаар чамтай ураг болсугай хэмээн” гэснээс илэрхий.

Энэ мэтчлэн Д.Нацагдоржийн шүлгүүдийг ажиглавал, сонирхолтой зүйлс олон байна. “Идэр хоёр” шүлгийг авч үзье. Энэхүү шүлэг нь бүхэлдээ хоёр буюу хосын бэлгэдлээс бүтсэн гэж хэлж болно. Жишээ нь:

Хос алаг нүд минь

Хоёр биедээ солонголно

Холбоо хоёр зүрх минь

Хувирахгүй янаглана

Цолмон хоёр нүд минь

Цогийн халуунаар ширтэлцэнэ

Цогцос хоёр зүрх минь

Цохихын тоогоор ярилцана

хэмээн эхний дөрвөн шадад 2 мөрөөр хослуулан, хайр сэтгэлт хүмүүсийн бие бие рүүгээ тэмүүлэх сэтгэлийн эрчим, тэмүүллийн хучийг хүний 5 мэдрэхүйгээс хамгийн чухал нь болох харах мэдрэхүйгээр дамжуулан нүдийг “цогийн халуун”-тай зүйрлэж, харин хүний бие эрхтнийг цохилох халуун зүрхээр амьдчилан дүрсэлжээ. Тэгэхдээ монголчуудын уламжлалт бэлгэдэл болох арга, билгийн ёсыг баримтлан бэлгэдсэн байна.

Идэр хоёр насны

Эвийг хэн ч эвдэхгүй

гэсэн дараагийн шадад эв эеийг дээдлэх монголчуудын уламжлалт бэлгэдлийг тусгажээ.

Харин энэхүү шүлгийнхээ гол санааг сүүлийн хоёр мөрөнд нэгтгэн

Өргөж босгосон тооно нь

Үүрд мөнх мандана гэж дуусгасан нь хайр сэтгэлт хосын босгосон гал голомт үүрд бадрах бэлгэдэл болжээ. Монголчуудын бэлгэдэх ёсонд гэрийн бэлгэдэл чухал үүрэгтэй бөгөөд тэрхүү гэрийн дээд хэсэг тооноор бэлгэдсэн байна. Тооно нь орчлон ертөнцийг гэрэлтүүлэн тэтгэгч алтан нарны бэлгэдэл, хорол эрдэнэ хэмээн бэлгэддэг тул айл гэрийн гал голомтын тухай ойлголтой салшгүй холбоотой байдаг. Ийнхүү уг шүлэг бүхэлдээ хос шад бүхий бэлгэдлийн цогцолбор уянга юм.

ХХ зууны 60-70-аад оны яруу найрагт шинэчлэл хийсэн “Дорнын их яруу найрагч” Б.Явуухулангийн шүлгээс үзье. Тэрээр “Би хаана төрөө вэ?” шүлэгтээ бэлгэдэл зүйн бүтвэр махбодыг хэрхэн ашигласан болохыг үзье. Шүлэг 12 бадаг, бадаг бүр нь 5 мөрөөр зохиомжлогдсон байдаг. Энэ нь монголчуудын эртнээс нааш бэлгэдэж ирсэн тооны болон цаг хугацаа, орон зайн бэлгэдэлтэй нягт холбоотой. Үүнд: 12 гэдэг нь монгол бэлгэдэл зүйд цаг хугацааны бэлгэдэл болсоор иржээ. Энэ тухай профессор С.Дулам “Арван хоёроор эс бэлгэдэх цагийн хугацал гэж үгүй... Чухам ийм учраас тооны бэлгэдлийн цогцолборт тэгш тооны тэнхлэг буюу хавтгай тэнхлэг дээр дөрвөн зүг, найман зовхисын хамт орон зайн цаг хугацааны цогцолборыг үүсгэн заларч байгаа юм” хэмээн өгүүлжээ. Эндээс ургуулан үзвэл, монгол гүн ухаанд хүний нас, биеийн нэг үеийг цаг хугацааны мөчлөгөөр тодорхойлон өгүүлж, 12 бадгаар бадаг бүр нь бие даасан утгатай, таван мөртэй санамсаргүй бус “арван хоёр цаг, арван хоёр сар, дөчин найман улирал, арван хоёр жил, түүнийг тав дахин нугалсан жарны тоолол”³ болох нь шүлэгт тусгалаа олжээ. Үүгээрээ яруу найрагч үеийн үед хэдэн жаранд монгол хүн, монгол орноо эзэгнэнхэн аж төрж, монголчуудын амьдрал тэмцэл эцэс төгсгөлгүй юм гэсэн санааг илэрхийлжээ.

Монгол шүлгийн 4 мөрөөр бадагладаг уламжлалыг баяжуулан, таван мөрөөр зохиомжилж, 1 ба 5 дахь хашлага, бадгийн утга санаагаа тодотгосон нь учиртай. Монгол ёсонд тавын тооны бэлгэдэл эв нэгдэл, хүч чадал, сайн сайхны бэлгэдэл болдог. Иймээс шүлгийн мөрийг таваар журамласан нь монголчуудын эв нэгдэл, дотоод хүчин чадал нь үүрд мөнх байхын бэлгэдэл гэж болох юм.

“Хөх манхан тэнгэрийг эзэгнэнхэн төрлөө би
Хөмсгөн сарны аялах алсын алс тойрогот
Холын хоёр одны тохиох бяцхан чөлөөнд
Хоёр нүдний үзүүрт цэнхэрлэх төдий тэртээд
Хөх манхан тэнгэрийг эзэгнэнхэн төрлөө би...”

бадагт хүний оюун ухаан хязгааргүй бөгөөд хөгжил дэвшлийн шинэ эринд сансар огторгуйг эзэгнэх болно гэсэн бэлгэдэлт санаа, нөгөө талаас монголчуудын эртний шүтээн болсон дээд тив буюу тэнгэр эцэг, мөнх хөх тэнгэр- үхэлгүй мөнхийн бэлгэдлийг агуулжээ. “Холын хоёр одны тохиох бяцхан чөлөө”, “хоёр нүдний үзүүрт цэнхэрлэх төдий тэртээ” хэмээх дүрслэлүүдэд “хоёр” гэсэн тооны нэрээр “энэ ертөнцийг бэлгэдэгч” тэгш тооны тэнхлэгийг үүсгэдэг³-ээс гадна хос ёсны сургаалыг бэлгэдэхийн зэрэгцээ монголчуудын алс холын зайл өнгөөр бэлгэдэх аргыг чадамгай илэрхийлжээ.

“...Цаст цагаан уулыг эзэгнэнхэн төрлөө би
Цан хүүрэг савсаж үүлс ороох оргилд
Цасан ширхэг царцаж мөс болох халилд
Царгия хүйтэн өвөл сарлагийн бух дошсон

Цааст цагаан уулыг эзэгнэнхэн төрлөө би

Онгон цэнхэр талыг эзэгнэнхэн төрлөө би

Орог саарал зэрэглээ хавар сүүмэлзэх хөндийд

Орсон буурын шүд өвөл хангинах хоолойд

Үлэг гүрвэлий мөрийг өдий хуртэл хадгалсан

Онгон цэнхэр талыг эзэгнэнхэн төрлөө би..."

Хоёр бадагт сансар огторгуйгаас цааст цагаан уул, онгон цэнхэр талд бууж ирэхдээ хүний таван махбодын нэг шороон махбодыг тусгасан байх магадлалтай бөгөөд хүний гар хүрээгүй онгон талыг сайн сайхны бэлгэдэл-цэнхэр өнгөтэй, говь нутгийн байгалийн өвөрмөц төрх болох зэрэглээг саарал өнгөтэй хоршуулан дурслэхдээ бүхэл бүтэн эрин үе, түүх соёлын дурсгалтай нь багтаан дурсэлжээ. Ингэхдээ сав өртөнцийг бүтээгч уул, ус, газар шороо эртний шим өртөнцийн үнэтэй дурсгалыг дурсэлж, түүнийгээ монгол орны байгалийн эрс тэс уур амьсгалын онцлог, тэрхүү хүйтэнд хувьсан өөрчлөгдхөн байгалийн өөрчлөлтийг шинжлэх ухааны үндэстэйгээр тусгасан нь содон юм.

"...Мөрөн голын усыг эзэгнэнхэн төрлөө би

Мөнгөн сарны сүүдэр толиорон хөвөх долгионд

Миний өвөг дээдсийн морин туурайнд наалдсан

Хүний нутгийн шороог ариун усаараа ундаалсан

Мөрөн голын усыг эзэгнэнхэн төрлөө би..."

Монголчууд эртний гайхамшигт түүх соёлтойг өгүүлээд таван махбодын нэг ус нь хүн төрөлхтний оршин тогтонох үндэс, шим өртөнцийн амьдралын эхлэл гэдгийг тусгажээ.

"...Үнэр ялдам агь гангыг эзэгнэнхэн төрлөө би

Үүр шөнийн завсар шүүдэр буух навчинд

Үрэл усан шүүдэрт нь одод гялалзах дэлбээнд

Үхэлгүй мөнхийн бэлгэдэл цагаан уул цэцгэнд

Үнэр ялдам агь гангыг эзэгнэнхэн төрлөө би..."

Энэхүү бадагт шим өртөнцийн нэг болох ургамлын сайхнаар төлөөлүүлэн, үхэлгүй мөнх байх санааг бэлгэдсэн аж. Учир нь монголчууд цагаан уул цэцгийг үхэлгүй мөнхийн бэлгэдэл хэмээн эртнээс үзэж, мөн мандан бадрахын бэлгэдэл галыг хэт, цагаан уул цэцгээр бадраан асаадаг, тэрчлэн үүрээр буух цэцгийн шүүдэр ариун тансагийн бэлгэдэл учраас шүүдрийн дусал цуглуулан, ээждээ цай чанаж өгвөл ачийг нь хариулна хэмээн үздэг зэргээс илэрхий.

"...Зүүрмэглэгч хун шиг гэрийг эзэгнэнхэн төрлөө би

Зүйдэлгүй цагаан өрхийн хоймсолж томсон оосорт

Зүрхэн улаан галтай ган тулгын тогтоонд

Зуун түмэн үед монгол хүний идээшсэн

Зүүрмэглэгч хун шиг гэрийг эзэгнэнхэн төрлөө би..."

Нүүдэлчин монголчуудын амьдралын гол хэрэгсэл монгол гэрийг тотем болсон хун швуутай зүйрлэн, хайр сэтгэлт хосуудын жаргалтай амьдрахын бэлгэдэл, өрх гэрийн мөнх оршихуйн бэлгэдэл болгон дурсэлжээ. Мөн нүүдэлч монголчуудын амьдралын онцлогт тохирсон, эд өлгийн өвөрмөц чухал дурсгал болох монгол гэрийг дэлхий өртөнцийн загвар болгон, тэгш хэмийн зарчмаар бэлгэдэж, хүн амьтныг дулаацуулан амьдруулагч, орчлонгийн гэрэл гэгээний эх үүсгэл болсон алтан нараар тооноо, түүний цацрагаар унийг төлөөлөн бэлгэдэж, тав тухтай амьдрал, айл гэрийн аж жаргалыг өгүүлсэн нь сонирхолтой юм. "Зүйдэлгүй цагаан өрх" гэсэн хэллэгээр тооноо,

өрхийг монгол гэрийн бэлгэдэлд гэрийн гал голомттой салшгүй холбоотой хэмээн үздэг заншил тэрчлэн хамгийн сайн сайхан бүхнийг эхийн цагаан сүүтэй зүйрлэн хиргүй тунгалаг, цэвэр ариун хэмээх бэлгэджээ. “Зүрхэн улаан галтай ган тулгын totgo” хэллэгээр айл гэрийн тулга нь эртнээс гал голомтоо мандаан бадраадаг ариун зүйл бөгөөд улаан өнгө нь энэхүү галын өнгө учир сүрлэг бадрангуй, мандан бадрахын бэлгэдлийг илэрхийлдгийг тус тус харуулжээ.

“...Сайхан бүсгүйн сэтгэлийг эзэгнэнхэн төрлөө би
Сормосон дундаа талимаарах алаг нүдний мэлмэрээнд
Саалийн үнэр ханхалсан дээлийн хормойн нугалаасанд
Санан санан уярах цэвэр ичимтгийн аашинд
Сайхан бүсгүйн сэтгэлийг эзэгнэнхэн төрлөө би...”

Монгол уламжлалт яруу найрагт бүсгүй хүний сайхныг таван мэдрэхүйгээр дүрслэн үзүүлдэг уламжлалыг шинэчлэн өвөрмөц маягаар нэгтгэн хүн төрөлхтний амьдралын эхлэл болсон хайр сэтгэлийг мөнх юм гэсэн бэлгэдэлт санааг илэрхийлжээ.

“...Тэнхээт хүлгийн дөрөөг эзэгнэнхэн төрлөө би
Тэлмэн жороо морины шанхны үзүүрийн чичиргээнд
Тэнгэрийн салхинаас бусдыг дээрээ гаргаж үзээгүй
Тэнэгэр.govийн сүрэг онгон хулангийн нуруунд
Тэнхээт хүлгийн дөрөөг эзэгнэнхэн төрлөө би...”

Малчин монголчуудын дээдлэн хүндэлдэг таван хошуу малын нэг нь морь билээ. Морийг эр хүний сайн нөхөр, молор эрдэнэ хэмээн дээдэлж, төрийн сүлдэндээ хүртэл морио дээдэлдэг. Эр чадлын бэлгэ тэмдэг болсон эрийн гурван наадмын нэг хурдан морины уралдаан, айргийн тавд орсон морины эзнийг хийморьтой гэдэг, түрүүлсэн морины хөлсөнд хурвэл бүтэн жилжингээ од хийморьтой байна гэдэг монголчуудын сэтгэхүйн онцлог болох бэлгэдэлт шинж ч туссан байна. Тэрчлэн энэхүү сайн сайхан, хүндлэл бишрэлийг, шандаст хурдан хүлгийн уг гарваль болох тэнгэрийн унага хулан, тахийн удамтай нь дүрсэлснээрээ монгол орны байгалийн баялаг ан амьтан дуусаж дундаршгүй санааг илэрхийлжээ.

“...Аадар хур бороог эзэгнэнхэн төрлөө би
Амгалан тэнгэрийг цочоох аянгын догшин гялбаанд
Ариун агаарт шүхэрлэх мөндрийн цагаан ширхэгт
Алтан талд татах солонгын долоон өнгөнд
Аадар хур бороог эзэгнэнхэн төрлөө би...”

Шим ертөнцийн амьдралын эх үүсгэл усыг сэлбэн тэтгэдэг аадар хур бороог, цэвэр ариуны бэлгэдэл агаарыг, тэрчлэн монгол домог зүйд долоон тоот гараг эрхсээр байгалийн сүр хүчинг бэлгэдэх бэлгэдлийг угсрулан бэлгэджээ.

“...Цээлхэн дууны эгшгийг эзэгнэнхэн төрлөө би
Цэнхэр хадган дээрх мөнгөн аягатай сарханд
Цээл сайхан эгшигтэй уртын дууны аянд
Цэнгэх зовох хосолсон хүний хувь заяанд
Цээлхэн дууны эгшгийг эзэгнэнхэн төрлөө би
Авхаалжит хүний биеийг эзэгнэнхэн төрлөө би
Амь нэгтэй олныхоо Монголоо Гэсэн сэтгэлд
Үүрийн таван жингээр хүдэр нэхэн улалзах
Үйлдвэрийн өндөр яндангийн хилэн улаан дөлөнд
Авхаалжит хүний биеийг эзэгнэнхэн төрлөө би...”

Хүний үйл ажиллагаанаас нийт улс орны хувь заяаг илтгэсэн өгүүлэмжээр ард түмний хөдөлмөр, бүтээн байгуулалт хүний амьдралын учир утга болсныг үйлдвэрийн яндангаас гарч байгаа хилэн улаан дөл буюу бадран дээшлэхийн бэлгэдэл болгож, оюуны соёлын үнэт өв болсон уртын дуугаар аз жаргалант амьдралыг алд цэнхэр хадагны бэлгэдлээр илэрхийлсэн ажээ.

“Хөх тэнгэрийн орныг эзэгнэнхэн төрлөө би

Хөх Монгол алдаршсаны үе дамжсан домогт

Хүчирхэг дээдсийн нутагт мандсан хувьсгалын дөлөнд

Хөрст алтан дэлхийн үрчлээт магнай болсон

Хөх тэнгэрийн орныг эзэгнэнхэн төрлөө би...”

Ингэж бадаг бүрт бэлгэдэлт шинжийг илэрхийлсний дараа “Хөх тэнгэрийн орныг эзэгнэнхэн төрлөө би” гэсэн энэхүү шадаар дээрх бүх бадгуудын санааг нэгтгэн дүгнэж, сансар огторгуй дээд тив буюу шим ертөнцөөс эхлэн, сав ертөнц, нийт хүмүүн төрөлхтний тухай гүн ухааны санааг гаргаж өгснөөрөө онцлог.

Монголчуудын гол шүтгээний нэг болох тэнгэр эцэг үхэлгүй мөнх гэсэн утгыг илэрхийлэхдээ “Хөх тэнгэрийн орон” гэжээ. Монголчууд тэнгэр гэдэг нь хүний овоун санаа, сүр сүлд, хүч хийморийг тэтгэгч хэмээн үздэг. Энэхүү “хөх тэнгэрийн орон”-оос “хөх монгол” хэмээн уусч орсон нь мөнх тэнгэрийн хүчин дор мандан бадарсан “Хөх монгол улс” гэсэн төрт ёсны бэлгэдлийг өгүүлсэн хэрэг юм. Эндээс Мөнх тэнгэрийн ивээлд орших Хөх Монгол улс ирээдүйд улам мандаж, хөгжин боловсрох юм гэсэн санааг илэрхийлсэн байна.

Дээрх зүйлүүдээс дүгнэвэл, энэхүү алдарт шүлэгт эх нутгийн төгс төгөлдөрийг дурслэхдээ монголчуудын эртний болон эдүгээгийн түүх соёл, хүн ардын сэтгэхүйн онцлог, гүн ухааны аяс бүхий бэлгэдэл зүйн бүтвэрүүдээс бүтсэн нь харагдаж байна.

Эх эцгийн элбэрэл журам нь хүн төрөлхтний бүхий л түүхээр боловсорсон бичигдээгүй хууль юм. Яруу найрагч бүр энэ хуулийн олон талыг өөрийн авьяас билэг, ур чадвар, билгийн хараагаар олж нээж байдаг. Орчин үеийн уран зохиолын нэрт төлөөлөгч Б.Лхагвасүрэнгийн уран бүтээлд эх үрсийн элбэрэл журам голлох байртай байдаг. Үүний нэг нь “Уянгын тойрог” шүлэг юм. Хүү Хасартаа зориулж бичсэн энэ шүлэгт эхийн хайр, эхийн сэтгэл, эхийн сайхныг ерийн нэг тоочин магтаагүй мөртлөө хэний ч санаанд ээжийгээ өөрийн эрхгүй хундлэн, хайрлан биширч дээдлэх аугаа их сэтгэлийг төрүүлдэг. Эх хүн завгүй байсан ч сэтгэлээрээ хүүтэйгээ хүйн холбоотой байдгийг тодорхой гаргахдаа монгол зан заншил, бэлгэдэл зүйг гайхамшигтай илэрхийлжээ. Одоо ажиглаж үзье.


Шүлгийн агуулгаас үзэхэд эцэгт дээл оёж буй эх хүний өгөөмөр нандин сэтгэл, энхрий хүүгээ хөлд ороход нь дэм түшиг болж, үйл бүтэхийг бэлгэдэж, тост хорвоод өөрийн мөрөө гаргах гэж тэмүүлэх хүүд гэрийн оосор бүслүүр дэм өгч, хөх тэнгэр нь татан босгож буй хийгээд гэрээ тойрон ажиггүй алхсаар үүдээр шагайх эхийгээ гайхшруулан баярлуулж, догдуулж байна.

Тооноор буусан наран дээр торгоны хээ золгуулан, учрал бэлгэдэн, аавд нь дээл оёж буй эхийн үйл бүтэхийн нигуур үйлэнд шамдан бүхнийг мартагнахын цагт үр нь гэрийнхээ доод бүслүүрээс дэм аван гишгэж байхыг олж хараагүй эхийн хөх чим хийж, хүүгээ үгүйлэн “миний хүү хаана байна” гэхүй, монгол гэрийн баруун хатавч, хоймор, зүүн “хатавчин тушаа үр нь aan” хэмээн хариу дуугарч зэждээ чимээ өгч буй тухай өгүүлсэн аж.

“...Газрын нар болсон хүү нь эхийнхээ дуунаас уяатай хөлд орж Налгар цагаан гэрээ тойрсон анхны мөр нь Нар сарны тэгийг газарт зурж буй...” хүүгийн өсч буй дүр зураг тодорно. Нөгөө талаас уг шүлэг бүхэлдээ монгол ахуй, монгол зан заншил, монгол сэтгэлгээний цогцолбор гэж болохоор аж. Тэнгэрийн нар гэр тойроод жаргаж, ирэх өдөр дахиад л урган манддаг бол эхийн нар болсон үр нь гэрээ нар зөв бүтэн эргээд хөлд орж байна.

Монгол эмэгтэйн уран үйл үндэсний хувцас дээлээ оёж шаглах монгол ахуй нь ч бэлгэдэл, нүүдэлчин амьдралтай монголчуудын үндэсний сууц болох монгол гэр, түүний бүтэц ч бэлгэдэл, нар зөв эргэх ёсыг баримтлан сайн сайхныг бэлгэддэг нь ч, ер нь монголчуудын амьдралд бэлгэдэл зүйн бүтвэр махбод элбэг гэдэг нь энэ шүлгээс харагдаж байна.

Тухайлбал, шүлэгт монголчуудын үндсэн сууц болох монгол гэр, түүний бэлгэдэл тодорхой тусгагджээ. Монгол гэрийг бүтээхэд орон зайн төсөөлөл, хэмжээсийн бэлгэдэл их нөлөөлжээ. “Ертөнцийн тухай бидний мэдлэгт дараалсан гурван шат байдаг.



Хэрэв байгалийн хуулиуд үзэгдлийг урьдаас хэлэх боломж олгодог бол, тэгш хэмийн зарчим нь байгалийн хуулиудыг урьдчилан хэлэх боломж олгодог. “хэмээн Л.Тарасов “Ертөнцийн тэгш хэмийн гайхамшиг” номдоо өгүүлсэн байdag.⁴ Ийм учраас монголчууд өөрсдийн үндсэн сууц болох монгол гэрийг барихдаа тэгш хэмийн зарчмыг харгалзан, эрт үеэс ацтай хусан баганаар тооноо тулдаг байсан нь одоо баруун зүүн багана болон хувираад байгаа билээ. Эрт үед энэхүү ацтай хусан багана нь бөөгийн ёс заншилд “гурван ертөнцийн гол тэнхлэг-удган мод учир аянга буудаггүй, бөх, хөнгөн” зэрэг бэлгэдлийг агуулдаг байсан ажээ. Тийм ч учраас монголчууд гэрээ эх дэлхийн загвар хэмээн бэлгэдэж, тэгш хэмийн зарчмаар бүтээсэн байдаг. Гэрийг бүтээхдээ тооныг алтан нарнаас, унийг нарны цацраг, хөрс газар шороог шал, уул нуруугаа хана гэх мэтээр загвар авч барьсан тухай ардын аман зохиолд ч өгүүлсэн байдаг.

Иймд гэрийн дотор ч гадна талд ч тэгш хэмийн зарчим-орон зайн хэмжээс үйлчилж байж гаднаа бөмбөгөр цагаан, дотроо алтан нарны цацраг хэлбэртэй баригдах ёстой юм. Монгол ардын аман зохиолд монгол гэрийг “найман тахилгат танан цагаан гэр” хэмээн бэлгэддэг. Энэ тухай профессор С.Дулам “Наймын тоо бол нарт ертөнцийг бэлгэддэг. ...Монгол гэрийг 88 унтай хийхийг эрхэмлэдэг нь нарт ертөнцийн бэлгэдэл болох наймын тооны олшруулсан хэлбэр бөгөөд 88 бол гэрэл гэгээ, сайн сайхны бэлгэдэл...” хэмээн өгүүлсэн байдаг.

Гэрийг барихдаа монголчуудын зүг чигийн бэлгэдлийг тусгасан байдаг нь уг шүлэгт ч бас илэрхийлэгджээ. Үүнд:

“...Миний хүү хаана байна гэж
Мэлтэн хөх тэнгэрт дуугаа цацна
Бадрангуйн хаан наран үнсэн жаргадаг
Баруун хатавчин тушаа
Бойтогны нь хонх тожигнон
Аан гэж хүү нь дуугарна
Амраг эхийн хөх нь чинэнэ
Чигчийн чинээн хүүгийн нь
Чимээ зуурхан алдарна
Үрээ л гэдэг ижийн нь
Үйлэн шаглаа төөрнө...”

хэмээн эхийгээ үйл мэтгэж байх хооронд гарсан хүү нь гэрийнхээ баруун хатавчин тушаа нар сарны тэгээр татуулан боссон зогсож байгаа тухай өгүүлсэн нь тэр айлын гал голомтын үргэлжлэл болсон хүү, нар зөв эргэн баруун талд очсон бэлгэдлийг тусгасан байна. Мөн

“...Миний хүү хаана байна гэж
Мяндас ээдрээн дуугаа цацна
Өрхний хоёр оосор үүрээр учирдаг
Өрлөг наран үдэд хажуулдаг
Алтан хоймор тушаа
Аан гэж хүү нь дуугарна
Ангир ижийн нь хөх ивэлиэ
Хуруун чинээ үрийн нь
Хонхны дуу хэсэгхэн алдарна
Зүстэй тортгын хээ хэрэлдэж
Зүүний нь үзүүр бүдэрнэ...”

хэмээн хүү, хоймор очсон байгаагаар дүрсэлсэн нь монгол ёсонд гэрийн баруун болон хойд зүг (хоймор) нь гэрийн эзний суудлыг бэлгэддэг, баруун зүгийг цагаан зүг хэмээн сайнаар бэлгэддэг заншлыг тусгасан байна.

“...Миний хүү хаана байна гэж
Мэлмий юугаа дүрлийлгэн дуудна
Тогоотой өрөм, дүүрэн саранг дуурайн загсаж хонодог
Тоостын шар наран, мэлтэгнэнхэн ургадаг
Зүүн хаяа тушаа
Аан гэж дуугарангаа
Газрын нар хүү нь
Үүдээр шагайна
Гайхамшигийг үүдэгч эхийн хөхнөөс
Сүү аяндаа асгарна...”

гэхэд наран ургах зүүн зүйт хүү нь гэрээ нар зөв бүтэн тойрч, анх хөлд орж байгаа тухай бэлгэджээ. Мөн баруун-зүүн, хойд-урд хэмээн эсрэгцэлдэж байгаа нь арга билгийн утгаараа аливаа зүйл эсрэг тэсрэгийн нэгдэл буюу тэнцвэрт байдалд байна гэсэн утгыг давхар илэрхийлж, монгол гэрийн бүтцийг тодорхой харуулжээ.

“...Тооноор бусан наран дээр
Хормой хумин
Тортгын хээ золгуулан

Учрал бэлгэдэн
Ижий нь
Эцгийн нь дээлийг оёно
Өөдрөг явахыг нь зөгнөж
Өвдгөөрөө энгэр захыг нь түшиэ
Тоонын шигшиг дуурailган
Торгон утас нар зөв даллана
Үйл бүтэхийн сэтгэл төвлөж
Үүлэн сүүдрийг мартахын цагт
Үр нь мөлхөж босго даван
Үүлгүй тэнгэрээр татуулж босно
Гэрийнхээ доод бүслүүрээс дэмнэж
Гишгэж анх үзин үр нь
Хөхөө гэнэт чим хийхэд
Хүүгээ үгүйлж сэргдхийнэх нь...”

Энэхүү гэрийн тооноор буусан наран дээр ээж нь учрал бэлгэдэн, аавд нь дээл эсгэхдээ сайн сайхан явахыг нь бэлгэдэн энгэр захыг нь өвдгөөрөө түшиж байгаа, мөн үйл мэтгэхдээ хүртэл тоонын шигшиг дууриалган, торгон мяндас нар зөв даллаж байгаа монгол эмэгтэйн мөрддөг өвөрмөц бэлгэдлийг харуулж байна. Монгол гэрийн тооно нь тэрхүү айлын гал голомтын бат бэх байдлыг бэлгэдсэн байdag.

Үүнээс гадна нүүдэлчин монголчуудын цаг тооллын нэгэн өвөрмөц бэлгэдэл уг шүлэгт тусгагдсан байна. Үүнд: “цагийн бэлгэдлийг ихэнх улс оронд дугуй тойрог дүрсээр тэмдэглэдэг ...”⁵ Монгол гэр нь дугуй хэлбэртэй тул малчин монголчууд эртнээс нааш гэрийн наран цагийг баримтлан бэлгэддэг байжээ. Энэ нь “бадрангуйн хаан наран үнсэн жаргадаг, өрлөг наран үдэд хажуулдаг алтан хоймор, тоостын шар наран мэлтэгнэнхэн ургадаг зүүн зүг хэмээн өгүүлсэн нь “өглөөний наран тоонын хуруунд байхад, нар хойморт байх, оройн нар тоонын хуруунд байхад”⁶ гэсэн наран цагтай тохирч байх юм.

Монгол бэлгэдэл зүйд нар, сарыг арга билгийн нэгдэл хэмээн үздэг.


“...Энхрийхэн нялх хүний үр
Эхийнхээ дуунаас уяатай хөлд орно
Налгар цагаан гэрээ тойрсон анхны мөр нь
Нар сарны тэгийг газарт зурна”

хэмээн нар, сарыг арга билгийн үүдиээс бэлгэдэн оруулжээ.

Энэ бүхнээс харвал, шүлэг бүхэлдээ монгол амьдралын нэгэн цогцолбор хөрөг болж, монгол ахуй ёс, монгол гэрийн бүтцийн бэлгэдэлт шинжийг, шүлгийн зохиомжтой нягт уялдуулан бичсэн байна. Энэхүү бэлгэдлийг загварчлан харуулбал:

Иймэйн дотор ч гади гади замаагаа илрүүлж ирүүнчилж чадахаа
үзүүлж байж ганцаа бамбогор цаган, дотров алтан үзүүлж чадахаа барилдах
сүүтэй бэхжүүлэх эхийнхийн нийт авьшиг сөрүүн чигүүтэй нийтийн дэхэз
зүйрэйн мэййэд эхийнхийн нийт авьшиг сөрүүн чигүүтэй түймрэйгээ
биймэдэг эхийнхийн нийт авьшиг сөрүүн чигүүтэй түймрэйгээ
болов. Иймэйдэж нийт авьшиг сөрүүн чигүүтэй түймрэйгээ
биймэдэг эхийнхийн нийт авьшиг сөрүүн чигүүтэй түймрэйгээ

Гэрийн барилдаа монголчуудын тут чийн багтадын нийт хийчнээс зөвхөн тут чийн нийт
туулж ч бас илрүүлж чадаа. Узас



Дүгнэлт

Дээрх зүйлүүдээс дүгнэлт хийж үзвэл, монголчууд аман ба бичгийн уран зохиолдоо бэлгэдэх ёс, бэлгэдэл зүйн аргыг эрт дээр үеэс эхлэн, өргөн хэрэглэж ирсэн бөгөөд энэ нь үе үеийн яруу найрагчдын бүтээлд тэдний ур чадварын өвөрмөц онцлогоос шалтгаалан, улам боловсронгуй болж, шинэчлэгдэн хөгжсөөр иржээ.

Орчин үеийн яруу найраг үүсч бий болсноос хойш бэлгэдэл зүйн арга хэмээн бие даасан тусгай арга болж хөгжөөгүй ч яруу найрагчдын уран бүтээлд ажиглалт хийн үзвэл, бэлгэдэл зүйн бүтвэр махбод шинэлэг байдлаар тусгагдсан нь ажиглагдаж байна.

Манай яруу найргийн гурван үеийн нэрт төлөөлөгчдийн шулгүүдийг ажиглавал, монгол ахуй, монгол зан заншлыг өөрийн гэсэн өвөрмөц ялгаатайгаар, тэгэхдээ бэлгэдэл зүйн тодорхой шинжүүдийг тусган харуулж чаджээ.

Ном зүй

1. Нацагдорж. Д., Бүрэн түүвэр, тэргүүн боть, УБ, 2006, 87-р тал
2. Явуухулан.Б., Түүвэр зохиол, I боть, УБ, 1985, 387-р тал
3. Галбаатар. Д., Монголын уран зохиолын онол, түүхийн зангилаа асуудлууд, УБ, 2001, 348-350 тал
4. Дулам.С., Монгол бэлгэдэл зүй, тэргүүн дэвтэр, УБ, 2002, 174-р тал
5. Мягмарсүрэн.С., Монгол гэрийн харц-хос чагтагын онол., МУИС, Ховд дахь салбар сургуулийн ЭШБ, №134, 78-81 тал
6. Дулам.С., Монгол бэлгэдэл зүй, дэд дэвтэр, УБ, 2002, 151-158 тал
7. Дулам.С., Монгол бэлгэдэл зүй, тэргүүн дэвтэр, УБ, 2002, 174-р тал
8. Лхагвасүрэн.Б., Түүвэр зохиол, тэргүүн боть, УБ, 2006, 17-р тал
9. Дулам.С., Монгол бэлгэдэл зүй, дөтгөөр дэвтэр, УБ, 2002, 244-р тал

SUMMARY

Generally, the literature of any nation evolves in a similar way with development of its history, society and culture. The history of written literature in Mongolia accounts over 1000 years and the poetry is rightfully acclaimed as having the deepest roots of tradition and widest popularity among people. Poetry is a sumptuous merit of the national mentality, the inner world of the human soul, its desires, goals as well as its cultural and artistic world.

The contemporary poetry in Mongolia is considered to be started after the national revolution. Its history begins with a revolutionary thematic song - "Shivee Khiagt", which was created by soldiers. Since that time, the Mongolian poetry has been developing and improving during over eighty years, on basis of a rich heritage of the written literature and the national folklore, adopting the best experiences of the world classical literature as well as reflecting the demands of present time.

In ancient times, the symbolic system has been developing in Mongolian literature including numbers, color, time, direction etc.

In this article, the author studied the specific feature of poetry by D.Natsagdorj, B.Yavuukhulan and B.Lkhagvasuren. The main purpose of this article is to investigate symbolism in their work. I attempted to make an explanation on the symbolic meaning of customs, aesthetic features and forms in the poetry from a point of traditional view. For example: Mongolian ger symbolizes a tiny figure of the world. Mongols have horizontal and vertical measures using them to make ger.